



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /31/ НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Орхон аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгэ худалдан авах тухай хууль
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдалт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
АО	Ажил олгогч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.24 № 12

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ТӨГСБАЯР
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>347,021,687.0</u>	<u>399,059,592.5</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,600.0	4,938,028.2
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,600.0	4,938,028.2
3121	Төгрөг	15,600.0	4,938,028.2
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	15,600.0	4,938,028.2
33	АВЛАГА	1,882,438.0	852,935.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,492,438.0	462,935.0
335	Бусад авлага	390,000.0	390,000.0
3351	Байгууллагаас авах авлага	390,000.0	390,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	345,123,649.0	393,268,629.4
351	Түүхий эд материал	280,533,400.0	331,011,705.9
35110	Тусгай зориулалттай материал	279,768,900.0	330,247,205.9
35130	Эм боох материал	764,500.0	764,500.0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	26,063,427.0	20,272,724.5
354	Хангамжийн материал	38,526,822.0	41,984,199.0
35410	Бичиг хэргийн материал	472,670.0	171,140.0
35420	Аж ахуйн материал	13,933,544.0	7,917,999.0
35450	Барилгын засварын материал	17,964,980.0	19,580,890.0
35460	Хүнсний материал	1,811,330.0	11,373,520.0
35470	Бусад хангамжийн материал	3,520,550.0	2,940,650.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,199,975,942.7</u>	<u>9,446,886,392.8</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,199,975,942.7	9,446,886,392.8
392	Биет хөрөнгө	8,418,133,297.5	8,670,503,313.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,453,870,210.0	8,453,870,210.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-436,752,504.9	-641,230,473.9
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,760,000.0	79,760,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81,760,000.0	-79,760,000.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,690,325,118.1	2,268,720,421.3
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,376,863,142.6	-1,498,718,834.3
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	191,841,676.9	191,271,494.9
39208	Хуримтлагдсан элэгдэл	-150,171,579.9	-162,896,088.9
39217	Ном	45,883,519.9	59,486,583.9
393	Биет бус хөрөнгө	781,842,645.2	776,383,079.8
39301	Програм хангамж	40,980,761.4	38,708,261.4
39302	Хуримтлагдсан элэгдэл	-32,578,116.2	-35,765,181.6
39303	Бусад биет бус хөрөнгө	773,440,000.0	773,440,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,546,997,629.6</u>	<u>9,845,945,985.3</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,455,189.0</u>	<u>7,819,038.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,455,189.0	7,819,038.0
413	Өглөг	0.0	2,363,849.0
4136	Бусад өглөг	0.0	2,363,849.0
41361	Байгууллагад төлөх өглөг		2,175,745.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	188,104.0
414	Урьдчилж орсон орлого	5,455,189.0	5,455,189.0
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	5,455,189.0	5,455,189.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>9,541,542,440.6</u>	<u>9,838,126,947.3</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	9,541,542,440.6	9,838,126,947.3

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,609,363,524.3	2,609,363,524.3
51101	Өмч: - төрийн	1,835,923,524.3	1,835,923,524.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	773,440,000.0	773,440,000.0
512	Хуримтлагдсан үр дүн	4,026,800,131.3	4,323,384,638.0
51210	Өмнөх үеийн үр дүн	4,151,093,297.3	4,025,417,693.3
51220	Тайлант үеийн үр дүн	-124,293,166.0	297,966,944.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,905,378,785.0	2,905,378,785.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,546,997,629.6</u>	<u>9,845,945,985.3</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,089,953,987.0	2,398,427,466.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	368,651,487.0	653,942,836.2
120	Нийтлэг татварын бус орлого	368,651,487.0	653,942,836.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	342,988,009.0	8,063,300.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,315,486.0	7,313,300.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	322,672,523.0	750,000.0
120005	Түрээсийн орлого	25,634,190.0	21,100,985.0
120009	Бусад орлого	29,288.0	0.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.0	600,282,051.2
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.0	24,496,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,721,302,500.0	1,744,484,630.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,709,280,500.0	1,666,009,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,709,280,500.0	1,666,009,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,022,000.0	78,475,330.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,564,000.0	9,680,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	38,324,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,458,000.0	30,471,330.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,213,037,278.9	2,100,381,414.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,213,037,278.9	2,100,381,414.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,855,134,548.1	1,921,218,137.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,060,752,660.0	1,121,118,254.6
210101	Үндсэн цалин	808,121,044.3	1,073,926,289.6
210102	Нэмэгдэл	142,503,311.5	1,624,365.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,297,042.1	45,567,600.0
210104	Урамшуулал	79,831,262.1	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,466,482.1	146,938,197.0
210201	Тэтгэврийн даатгал	87,014,384.6	103,777,555.0
210202	Тэтгэмжийн даатгал	10,900,395.7	11,159,788.0

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	8,668,332.5	8,927,830.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,359,750.0	2,086,061.0
210205	Эрүүл мэндийн даатгал	24,523,619.3	20,986,963.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,935,293.6	103,889,794.5
210301	Гэрэл, цахилгаан	21,132,172.9	14,841,979.3
210302	Түлш, халаалт	68,410,807.0	65,504,939.7
210303	Цэвэр, бохир ус	11,392,313.7	23,542,875.5
2104	Хангамж, бараа материалын зардал	57,666,249.1	71,114,837.5
210401	Бичиг хэрэг	3,356,820.0	3,582,830.0
210402	Тээвэр, шатахуун	2,764,976.0	4,083,748.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,688,441.5	3,167,872.9
210404	Ном, хэвлэл	0.0	57,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,647,500.0	14,619,100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,863,550.0	5,279,600.0
210408	Бараа материал акталсны зардал	39,344,961.6	40,324,486.6
2105	Нормативт зардал	16,527,852.0	41,718,360.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	506,680.0	9,225,000.0
210502	Хоол, хүнс	13,417,972.0	32,233,360.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,603,200.0	260,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,247,600.0	22,991,300.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,200.0	475,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0	251,000.0
210604	Урсгал засвар	1,208,400.0	22,265,300.0
2107	Томилолт, зочны зардал	550,000.0	250,400.0
210702	Дотоод албан томилолт	550,000.0	250,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,053,700.0	15,037,700.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,252,700.0	9,580,300.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,500,000.0	3,100,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,000.0	65,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	42,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	923,000.0	2,242,400.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		7,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	475,934,711.3	398,159,294.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	20,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	65,630,699.0	44,846,800.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	410,304,012.3	353,292,494.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	357,902,730.8	179,163,276.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,640,890.0	149,401,797.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,403,300.0	42,254,297.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,236,300.0	103,471,500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,001,290.0	3,676,000.3
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	268,261,840.8	29,761,479.6
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	268,261,840.8	29,761,479.6

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-123,083,291.9</u>	<u>298,046,051.4</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,209,874.1	79,106.7
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,209,874.1	79,106.7
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,209,874.1	-79,106.7
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-124,293,166.0</u>	<u>297,966,944.7</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,363,524.3	2,905,378,785.0	4,151,093,297.3	9,665,835,606.6
C07	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-124,293,166.0	-124,293,166.0
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,363,524.3	2,905,378,785.0	4,026,800,131.3	9,541,542,440.6
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,609,363,524.3	2,905,378,785.0	4,026,800,131.3	9,541,542,440.6
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	-1,382,438.0	-1,382,438.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,609,363,524.3	2,905,378,785.0	4,025,417,693.3	9,540,160,002.6
D08	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	297,966,944.7	297,966,944.7
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,363,524.3	2,905,378,785.0	4,323,384,638.0	9,838,126,947.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		0.0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,770,294,692.0</u>	<u>1,772,933,397.0</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,583,138.0	28,414,285.0
120	Нийтлэг татварын бус орлого	32,583,138.0	28,414,285.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,583,138.0	7,313,300.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,874,660.0	7,313,300.0
120005	Түрээсийн орлого	25,634,190.0	21,100,985.0
120009	Бусад орлого	74,288.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,737,711,554.0	1,744,519,112.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,709,280,500.0	1,666,009,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,709,280,500.0	1,666,009,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,022,000.0	78,475,330.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,564,000.0	9,680,000.0

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	38,324,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,458,000.0	30,471,330.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,409,054.0	34,482.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	16,409,054.0	34,482.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,773,924,692.0</u>	<u>1,768,010,969.8</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,773,924,692.0	1,768,010,969.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,399,704,247.2	1,588,813,210.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,060,712,660.0	1,118,223,777.7
210101	Үндсэн цалин	759,504,439.7	701,035,931.9
210102	Нэмэгдэл	184,006,687.5	304,799,988.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,403,695.2	47,190,456.0
210104	Урамшуулал	80,797,837.6	65,197,401.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,466,482.1	147,821,760.1
210201	Тэтгэврийн даатгал	87,014,381.8	103,559,774.0
210202	Тэтгэмжийн даатгал	10,900,395.9	11,448,733.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,668,332.5	9,058,186.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,359,751.0	2,153,472.8
210205	Эрүүл мэндийн даатгал	24,523,620.9	21,601,592.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,935,293.6	103,889,794.5
210301	Гэрэл, цахилгаан	21,132,172.9	14,841,979.3
210302	Түлш, халаалт	68,410,807.0	65,504,939.7
210303	Цэвэр, бохир ус	11,392,313.7	23,542,875.5
2104	Хангамж, бараа материалын зардал	22,773,161.5	31,189,620.9
210401	Бичиг хэрэг	2,986,850.0	3,421,500.0
210402	Тээвэр, шатахуун	2,847,020.0	3,260,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,688,441.5	3,167,872.9
210404	Ном, хэвлэл	0.0	57,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,216,400.0	15,396,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,034,450.0	5,886,448.0
2105	Нормативт зардал	18,797,440.0	74,156,305.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	293,130.0	9,225,000.0
210502	Хоол, хүнс	15,326,930.0	43,971,705.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,770,800.0	20,959,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	641,000.0	35,293,450.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	641,000.0	720,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0	3,150,000.0
210604	Урсгал засвар	0.0	31,423,450.0
2107	Томилолт, зочны зардал	550,000.0	250,400.0
210702	Дотоод албан томилолт	550,000.0	250,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,053,700.0	15,060,200.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,252,700.0	9,399,300.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,500,000.0	3,100,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,000.0	65,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	42,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	923,000.0	2,453,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,774,510.0	62,927,902.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,774,510.0	62,927,902.0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,365,184.0	179,197,759.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,365,184.0	149,401,798.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	16,409,054.0	1.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,403,300.0	58,474,297.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,236,300.0	87,251,500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,316,530.0	3,676,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	29,795,961.6
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	268,261,840.8	29,795,961.6
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-3,630,000.0</u>	<u>4,922,427.2</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-3,630,000.0	4,922,427.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,645,600.0	15,600.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,600.0	4,938,027.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Дүн	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,694,009,300.0	1,665,061,934.4	28,947,365.6	98.3%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,694,009,300.0	1,665,061,934.4	28,947,365.6	98.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,544,605,300.0	1,515,660,137.4	28,945,162.6	98.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,112,580,300.0	1,112,579,500.0	800.0	100.0%
210101	Үндсэн цалин	683,852,600.0	695,391,654.2	-11,539,054.2	101.7%
210102	Нэмэгдэл	303,744,700.0	304,799,988.8	-1,055,288.8	100.3%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,814,000.0	47,190,456.0	-2,376,456.0	105.3%
210104	Урамшуулал	80,169,000.0	65,197,401.0	14,971,599.0	81.3%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,049,500.0	151,049,500.0	0.0	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	103,794,100.0	107,048,454.9	-3,254,354.9	103.1%
210202	Тэтгэмжийн даатгал	11,813,800.0	11,383,498.9	430,301.1	96.4%
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,451,100.0	9,005,998.9	445,101.1	95.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,362,800.0	2,140,425.8	222,374.2	90.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	23,627,700.0	21,471,121.4	2,156,578.6	90.9%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,473,700.0	103,889,794.5	26,583,905.5	79.6%
210301	Гэрэл, цахилгаан	28,121,200.0	14,841,979.3	13,279,220.7	52.8%
210302	Түлш, халаалт	84,955,800.0	65,504,939.7	19,450,860.3	77.1%
210303	Цэвэр, бохир ус	17,396,700.0	23,542,875.5	-6,146,175.5	135.3%
2104	Хангамж, бараа материалын зардал	19,775,700.0	19,705,920.9	69,779.1	99.6%
210401	Бичиг хэрэг	3,108,500.0	3,421,500.0	-313,000.0	110.1%
210402	Тээвэр, шатахуун	2,400,000.0	3,260,000.0	-860,000.0	135.8%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,290,100.0	3,167,872.9	1,122,227.1	73.8%

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,446,900.0	7,406,100.0	-959,200.0	114.9%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,530,200.0	2,450,448.0	1,079,752.0	69.4%
2105	Нормативт зардал	36,359,200.0	36,359,200.0	0.0	100.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,169,600.0	8,169,600.0	0.0	100.0%
210502	Хоол, хүнс	20,400,000.0	20,400,000.0	0.0	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,789,600.0	7,789,600.0	0.0	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,491,000.0	18,490,322.0	678.0	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	720,000.0	720,000.0	0.0	100.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,150,000.0	3,150,000.0	0.0	100.0%
210604	Урсгал засвар	14,621,000.0	14,620,322.0	678.0	100.0%
2107	Томилолт, зочны зардал	250,400.0	250,400.0	0.0	100.0%
210702	Дотоод албан томилолт	250,400.0	250,400.0	0.0	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,350,200.0	15,060,200.0	2,290,000.0	86.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,399,300.0	9,399,300.0	0.0	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,280,000.0	0.0	2,280,000.0	0.0%
210803	Даатгалын үйлчилгээ	3,100,000.0	3,100,000.0	0.0	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,000.0	65,000.0	10,000.0	86.7%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,500.0	42,500.0	0.0	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,453,400.0	2,453,400.0	0.0	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,275,300.0	58,275,300.0	0.0	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58,275,300.0	58,275,300.0	0.0	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,404,000.0	149,401,797.0	2,203.0	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	149,404,000.0	149,401,797.0	2,203.0	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,476,500.0	58,474,297.0	2,203.0	100.0%
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	87,251,500.0	87,251,500.0	0.0	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,676,000.0	3,676,000.0	0.0	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,694,009,300.0	1,665,061,934.4	28,947,365.6	98.3%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,666,009,300.0	1,636,647,649.4	29,361,650.6	98.2%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,666,009,300.0	1,636,647,649.4	29,361,650.6	98.2%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	28,000,000.0	28,414,285.0	-414,285.0	101.5%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,000,000.0	28,414,285.0	-414,285.0	101.5%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.0	100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1	0.0	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	85	85	0.0	100.0%
620001	Удирдах ажилтан	3	3	0.0	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	52	52	0.0	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	30	31	0.0	100.0%

63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	796	796	0.0	100.0%
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	796	796	0.0	100.0%
632001	Төрийн өмчит МСҮТ	796	796	0.0	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	85	88	0.0	100.0%
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	50	50	0.0	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	35	35	0.0	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,022,000.0	78,475,330.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,022,000.0	78,475,330.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,476,465.0	78,075,501.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,613,365.0	6,523,525.0
210101	Үндсэн цалин	2,613,365.0	6,523,525.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	375,000.0	815,441.0
210201	Тэтгэврийн даатгал	375,000.0	554,500.0
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	65,235.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	52,188.0
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	13,047.0
210205	Эрүүл мэндийн даатгал	0.0	130,471.0
2104	Хангамж, бараа материалын зардал	48,100.0	11,483,700.0
210404	Ном, хэвлэл	0.0	57,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	0.0	7,990,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,100.0	3,436,000.0
2105	Нормативт зардал	780,000.0	37,797,105.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.0	1,055,400.0
210502	Хоол, хүнс	780,000.0	23,571,705.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	13,170,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	16,803,128.0
210604	Урсгал засвар	0.0	16,803,128.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,910,000.0	4,652,602.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,910,000.0	4,652,602.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	399,829.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,545,535.0	399,829.0
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,545,535.0	399,829.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,022,000.0	78,475,330.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,022,000.0	78,475,330.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,564,000.0	9,680,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	38,324,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,458,000.0	30,471,330.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн чиг үүргийг Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 12.1-д “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **дунд** гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 1,694,009.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 25,410.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,057.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 298,948.4 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна. Нийт хөрөнгийн өсөлт нь тайлант оны бараа материал, үндсэн хөрөнгийн өсөлттэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15.6	4,938.0	4,922.4
Авлага	1,882.4	852.9	-1,029.5
Урьдчилгаа			
Бараа материал	345,123.7	393,268.7	48,145.0
Үндсэн хөрөнгө	9,199,975.9	9,446,886.4	246,910.5
Нийт хөрөнгө	9,546,997.6	9,845,946.0	298,948.4
Өр төлбөр	5,455.2	7,819.0	2,363.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,541,542.4	9,838,126.9	296,584.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,546,997.6	9,845,946.0	298,948.4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,938.0 мянган төгрөг болж 4,922.4 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын санд оны эцэст цалин болон ндш-ын зардлаас мөнгөн хөрөнгө төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 1,029.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд насжилт өндөртэй 1,382.4 мянган төгрөгийн авлага буурч 352.9 мянган төгрөгийн авлага нэмэгджээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 393,268.7 мянган төгрөг болж 48,145.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал, хүнсний материалын өсөлттэй холбоотой байна. Тус төвийн оюутны дотуур байрыг тайлант онд Ковид -19 өвчлөлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зориулж ашигласан байснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,446,886.4 мянган төгрөг болж 246,910.5 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант оны элэгдлийн зардал 353,292.5 мянган төгрөг хэдий ч үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 623,107.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн тул үндсэн хөрөнгийн данс өссөн байна. Мөн ТӨБЗГ-ын шийдвэрээр 13,126.4 мянган төгрөгийн дансны үнэтэй 13,047.3 мянган хуримтлагдсан элэгдэлтэй машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамж акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,819.0 мянган төгрөг болж 2,363.8 мянган төгрөгөөр өссөн нь цалингаас суутгасан үйлдвэрчний эвлэлийн гишүүний татварын өглөгт 2,175.7 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх өглөгт /ХХОАТ-ын хөнгөлөлтийн зөрүү, нийгмийн даатгалаас олгох лист зэрэг/ 188.1 мянган төгрөг үүсгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,838,126.9 мянган төгрөг болж 296,584.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 308,473.5 мянган төгрөгөөр буюу 14.8 хувиар өссөн байна. Өмнөх оноос орлого өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон нэмэлт санхүүжилтийн орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 112,655.9 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,063,971.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,063,971.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бууруулж, тус байгууллагын 2021 оны төсвийг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 1,773,193.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 28,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоос бүрдүүлж, нийт зарлагыг 1,801,93.8 мянган төгрөгөөр тооцон баталж төсвийн хуваарь ирүүлсэн байна. /2021 оны 01 сар/.

Баталж ирүүлсэн төсвийн хуваарийг тодотгож 107,184.5 мянган төгрөгөөр бууруулж 1,694,009.3 мянган төгрөгөөр шинэчлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71804 /Мэргэжлийн боловсрол/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,694,009.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,666,009.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 28,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,694,009.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 28,414.3 мянган төгрөг, нийт 1,694,423.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,665,061.9 мянган төгрөгийг зарцуулж 29,361.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,665,061.9 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 26,583.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,290.0 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны 78,475.3 мянган төгрөгийн гүйлгээ тайлагнасан байна. Оюутны дотуур байрыг Ковид – 19 өвчний эмнэлгийн тусламж үйлчилгээний байраар ашиглаж байсантай холбоотойгоор цалин хөлс, ндш-ийн дардалд 7,339.0 мянган төгрөг, хоол хүнс, нормын хувцас, зөөлөн эдлэл буюу нормативд зардалд 37,797.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 11,483.7 мянган төгрөг зарцуулж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 136 талбарын мэдээлэл, 12 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 3 талбарын

мэдээллийг огт мэдээлээгүй байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын 286,021.0 мянган төгрөгийн 26 гүйлгээг байршуулаагүй байсныг нөхөж мэдээлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1,115.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бүрэн төлөгдсөн, 6,198.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 3 зөвлөмж хүргүүлсэн ба биелэлт хангагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 828,343.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 810,716.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,031.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 10,080.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,515.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан 624,778.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг хандив тусламжийн орлогоор, нэмэлт санхүүжилтийн болон үйл ажиллагааны 85,788.6 мянган төгрөгийн орлолыг бусад орлогоор бүртгэж орлогын ангилал алдаатай илэрхийлсэн байна.
- Санхүүгийн байдлын тайланд ндш-ийг авлагыг 10.0 мянган төгрөгөөр дутуу, 1 ажилтанд илүү шилжүүлсэн өөр ажилтанд өгөх 49.9 мянган төгрөгийн ХЧТА-ын тэтгэмжийн мөнгийг авлага, өглөгөөр тусгаагүй, мөн оны эцэст татуулсан ХЧТА-ын тэтгэмжийн 34.5 мянган төгрөгийн авлагыг өглөгөөр тус тус бүртгээгүй, бараа материалыг 27.4 мянган төгрөгөөр тус тус алдаатай тайлагнасан байна.
- Элэгдлийн зардлыг 74,977.7 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, бараа материал акталсны 19,404.8 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд, цалингийн зардлын 114.5 мянган төгрөгийг төвлөрүүлэх шилжүүлгээр, мөнгөн гүйлгээний тайланд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн 607.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж болон нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаар тус тус алдаатай илэрхийлсэн байна. Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланд оны эцэст ахмадын санд шилжүүлсэн 4,922.4 мянган төгрөгийн тохируулах бичилт хийгээгүй байна.

4.2 Төлбөрийн акт

1. Тус байгууллага нь шинээр мэргэжлийн зэрэг авсан ажилчдын зэргийн нэмэгдэлд 2,531,159 төгрөгийн цалин илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/27 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”-ын 4.1-д “Мэргэжлийн зэрэг шинээр олгосон багшид нэмэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгоно” гэж заасантай нийцэхгүй, хэмжилт болон үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

2. Холбогдох анхан шатны баримтгүйгээр, зориулалт бусаар 1,500,000 төгрөгийн шатахуун талон зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов

4.3 Албан шаардлага

1. Тайлант онд /11, 12-р сард/ 10,080.0 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны жилийн дүнгээр цалингийн зардлаас АО-с төлөх НДШ-ийн зардалд 883.5 мянган төгрөг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр цалин, АО-с төлөх НДШ-ийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2,279.4 мянган төгрөгийн өр төлбөр, 352.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 136 талбарын мэдээлэл, 12 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 3 талбарын мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"

гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай тус тус нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, цахим хуудаст мэдээлэх мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт мэдээлж, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Орхон аймаг дахь МСҮТ	1	2,531.2			1	2,531.2				
2	Орхон аймаг дахь МСҮТ	1	1,500.0			1	1,500.0				
3	Орхон аймаг дахь МСҮТ	1	10,080.0					1	10,080.0		
4	Орхон аймаг дахь МСҮТ	1	710,567.1	1	710,567.1						
5	Орхон аймаг дахь МСҮТ	1	121.8	1	121.8						
6	Орхон аймаг дахь МСҮТ	1	100,027.2	1	100,027.2						
7	Орхон аймаг дахь МСҮТ	1	0.0							1	0.0
8	Орхон аймаг дахь МСҮТ	1	883.5							1	883.5
9	Орхон аймаг дахь МСҮТ	1	2,632.3							1	2,632.3
Дүн		9	828,343.1	3	810,716.1	2	4,031.2	1	10,080.0	3	3,515.8